



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 22 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 22 дугаар хуралдаан 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр болов.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 22 дугаар хуралдаанаар /2025-10-30/ Интернэтэд суурилсан (ОТТ) олон суваг дамжуулах үйлчилгээний өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай танилцуулга (Хорооны 2025 оны ээлжит 12 дугаар хуралдаанаас өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх); Улаанбаатар хотод арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийн тухай (Хорооны 2025 оны 115, 206, 207, 208 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэх); Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт;) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 12 (Тогтоол №227-238, 2025-10-30) тогтоолыг тус тус батлан шийдвэрлэв.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 12 дугаар хуралдаанаар /2025-05-29/ нэр бүхий хорооны гишүүнээс Интернэтэд суурилсан (ОТТ) олон суваг дамжуулах үйлчилгээний өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай танилцуулга, судалгаа хийж, Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг Ажлын алба, ӨНЗГ-т үүрэг болгосон юм. ХХЗХ-ны 2025 оны ээлжит 22 дугаар хуралдаанаар уг үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд ӨНЗГ-аас “Интернэтэд суурилсан (ОТТ) олон суваг дамжуулах үйлчилгээний өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай танилцуулга”-ыг сонсож, хэлэлцсэн асуудлаар холбогдох анхаарч ажиллах удирдамж чиглэлийг хариуцсан ажлын алба, бүтцийн нэгжид үүрэг болгов.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 19 дүгээр хуралдаанаар “Улаанбаатар хотод Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт” (2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 206 тоот тогтоол); “Говьсүмбэр, Дундговь аймгийн нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт” (2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 207 тоот тогтоол); Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дундговь аймагт “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл болон “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт (2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 208 тоот тогтоол)-ыг тус тус дахин зарлахаар шийдвэрлэсэн болно. Үүнд:

1. ХХЗХ-ны 2025 оны 206 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор АрТВ-Улаанбаатар хот-2025-2 тоот “Улаанбаатар хотод Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс 30 хоногийн хугацаатай зарласан;

2. ХХЗХ-ны 2025 оны 207 тоот тогтоолыг тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор АрТВ-Орон нутаг-2025-2 тоот “Говьсүмбэр, Дундговь аймгийн нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс 30 хоногийн хугацаатай зарласан:
3. ХХЗХ-ны 2025 оны 208 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор АрР-Орон нутаг 2025-2 тоот “Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дундговь аймагт “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл болон “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс 30 хоногийн хугацаатай зарласан болно.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 22 дугаар хуралдаанд дээр заасан нэр бүхий 3 сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан Үнэлгээний ажлын хэсгийн зохион байгуулсан АрТВ-Улаанбаатар хот-2025-2 тоот “Улаанбаатар хотод Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ын үйл ажиллагаа, үнэлгээ гүйцэтгэсэн тайлан тэмдэглэл, холбогдох танилцуулга, үнэлгээний ажлын хэсгийн санал дүгнэлт болон “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” 2 тогтоолын төслийг тус тус авч хэлэлцэв. Тус хуралдаанаар 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” 2 тогтоолыг батлан шийдвэрлэв. Үүнд:

1. Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны “Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай” 2025 оны 115 дугаар тогтоол, Сонгон шалгаруулалт дахин зохион байгуулах тухай 2025 оны 206 дугаар тогтоол, тус хорооны даргын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/227 тоот тушаалаар байгуулсан үнэлгээний ажлын хэсгийн 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 227 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг батлав. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, Тус хорооноос 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр зарласан “Улаанбаатар хотод арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-д Эн Ти Ви Бродкастинг ХХК-ийг шалгарсанд тооцсугай. Тогтоолын 2 дугаар заалтад, Сонгон шалгаруулалтад шалгарсан Эн Ти Ви Бродкастинг ХХК-д Улаанбаатар хотод арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 2030 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгосугай. Тогтоолын 3 дугаар заалтад, Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай. Тогтоолын 4 дүгээр заалтад, Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.
2. Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1

дэх хэсэг, 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны “Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай” 2025 оны 115 дугаар тогтоол, Сонгон шалгаруулалт дахин зохион байгуулах тухай 2025 оны 206 дугаар тогтоол, тус хорооны даргын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/227 тоот тушаалаар байгуулсан үнэлгээний ажлын хэсгийн 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 228 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг батлав. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, Тус хорооноос 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр зарласан “Улаанбаатар хотод арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-д Ууган суваг ХХК-ийг шалгарсанд тооцсугай. Тогтоолын 2 дугаар заалтад, Сонгон шалгаруулалтад шалгарсан Ууган суваг ХХК-д Улаанбаатар хотод арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 2030 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгосугай. Тогтоолын 3 дугаар заалтад, Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай. Тогтоолын 4 дүгээр заалтад, Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 22 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 10 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 10 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 229 тоот тогтоолыг баталж, тогтоолоор нэр бүхий 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (ЮЭСЖИ очлоо экспресс ХХК: “Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 230 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 2 хуулийн этгээдэд 2 тусгай зөвшөөрлийг (Мөнх бат мобайл Эм Би Эм ХХК, Рекон повер ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10, 14 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 231 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг (Софт ринг ХХК: 11800397 тоот, Харцаган жин ХХК, 12100456 тоот; Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа

холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар сунгасан;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 232 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Цацраг трейд ХХК: Дорнод аймгийн нутаг дэвсгэрт “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх” 13400030 тоот тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын 5.5 дахь хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 233 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 3 тусгай зөвшөөрөлд (Манай аялгуу эф эм ар ХХК-ийн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Арилжааны радиоогийн үйлчилгээ эрхлэх” 12800168 тоот тусгай зөвшөөрөл болон “Радио давтамж радио давтамжийн зурвас ашиглах” 22800178, 22830004 тоот тусгай зөвшөөрлүүдийн “VIP FM 90.5” радиоогийн нэрийг “Орос радио 90.5 77.7” болгон) өөрчлөлт оруулсан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Амекс Эм Эн Жи ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 234 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Амекс Эм Эн Жи ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх” 43200111 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, ОРЧС ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 235 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (ОРЧС ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх” 43200175 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Цахим төгс хурд ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 236 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Цахим төгс хурд ХХК: Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх” 13600153 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 237 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд (Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар: 1116) 1 харилцаа холбооны сүлжээний дугаарыг 2 жилийн хугацаагаар олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 238 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд олгосон (Ньютел ХХК: 1900-1199) 1 харилцаа

холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилээр сунгаж тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг [энд дарж](#) үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-11-09